



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

Үйлдвэрчний эвлэлийн гудамж 37, 29 дүгээр хороо,

Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18072

Утас: 7018 1208, 7018 1447, 7018 1206,

Цахим шуудан: info@ngs.gov.mn,

Цахим хуудас: www.ngs.gov.mn

2024.01.29 № 2/44

танай _____-ны № _____-т

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

2023 оны жилийн эцсийн байдлаар Үндэсний геологийн албаны Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд батлагдсан төлөвлөгөөний дагуу Нийгмийн баталгаа болон Сургалтын тайланг хавсралтаар хүргүүлж байна.


Хавсралт  хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА С.ШИНЭ-ОД



182405 045

**ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ АЛБАН ХААГЧДЫН
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН 2023 ОНЫ ТАЙЛАН**



№	Үйл ажиллагааны чиглэл	Зохион байгуулах ажил	Хэрэгжилт
1	Ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх чиглэлээр	Ажилтан ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд шаардлагатай компьютер, техник хэрэгслийн судалгаа хийж, удирдлагад танилцуулах, зайлшгүй шаардлагатай техник хэрэгслийг захиалж, ажилтныг хэвийн ажиллах нөхцөлөөр хангах /Компьютер, сканер, камер, сейф, ажлын хувцас, багаж төхөөрөмж г.м/	Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор нийт 181.4 сая.төг зарцуулсан. Үүнд: Компьютер, техник хэрэгсэл болон ажлын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж – 42 сая.төг Урсгал засвар – 73 сая.төг Хүнд хортой нөхцөлийн сүүний зардал - 8.4 сая.төг Түлээ нүүрсний хөнгөлөлт – 1.4 сая.төг Шинээр төрсөн хүүхэд – 0.6 сая.төг Эрүүл мэндийн шалтгаантай 3 сарын цалинтай чөлөө Үр дүнгийн урамшуулал – 56 сая.төг
2	Тусламж дэмжлэгийн чиглэлээр	Ажилтанд тусламж дэмжлэг шаардлагатай болсон тухай бүрд журмын дагуу шийдвэр гаргах, дэмжлэг тусламж үзүүлэх	2023 оны 05 сарын 31-ний Б/15 дугаар тушаалаар нийт 28 албан хаагчийн ээлжийн амралтын хуваарийг баталж, хуваарийн дагуу амралтыг биеэр эдлүүлсэн. Албан хаагчаас чөлөө хүссэн -4, ажлаас чөлөөлөгдөх -9, ажилд орох -13, сургалтад хамрагдах 2, шилжин ажиллах 3, нийт 31 өргөдөл хүлээн авч холбогдох хууль журмын дагуу шийдвэрлүүлсэн. Тайлант хугацаанд буцалтгүй тусламж буюу арын гачигдал гарсан 3, гэр бүлийг дэмжих 1 (шинээр гэрлэлтээ батлуулсан), нүүрс түлээний хөнгөлөлт 7, нийт 11 албан хаагчид тусламж дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэсэн. Хэвийн бус нөхцөлд ажилладаг 11 албан хаагчид тогтмол нөхөн олговор олгож ажилласан.
3	Тусламж дэмжлэгийн чиглэлээр	Өндөр насны тэтгэвэрт гарах ажилтан албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн дагуу нэг удаагийн тэтгэмж олгох	2023 оны 1-р улиралд багтан 2023 онд тэтгэвэрт гарах 1 албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн дагуу нэг удаагийн тэтгэмж олгох 38.8 сая.төгрөгийг байгууллагын 2023 оны төсөвт төлөвлөж батлуулан олгосон.
4	Албан хаагчдын сургалт хөгжлийн чиглэлээр	"УГА-ны ажиллагсдын 2023 оны сургалтын төлөвлөгөө"-г Агентлагийн даргаар батлуулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг сургалтад жигд хамруулах	2023 оны сургалтын төлөвлөгөөг нэгжүүдийн хэрэгцээ шаардлага саналыг үндэслэн боловсруулж, албаны даргаар батлуулсан. Сургалтын төлөвлөгөөний дагуу Хувь хүний хөгжил, манлайллын чиглэлээр 4 төслийн 6 сургалт, төрийн болон хувийн байгууллагын 8 сургалт, ТА3-өөс зохион байгуулсан 7 сургалт, мэргэжлүүлэх чиглэлээр 5 байгууллагаас зохион байгуулсан 13 сургалт, Удирдлагын академийн Төрийн албан хаагчийн 4 багц сургалт гэх мэт нийт 38 төрлийн сургалтад давхардсан тоогоор 256 албан хаагч хамрагдсан. Сургалтын дэлгэрэнгүй тайланг хавсаргав.
5	Албан хаагчдын сургалт хөгжлийн чиглэлээр	Төрийн болон өөрийн хөрөнгөөр даатан сурах, мэргэшлээ дээшлүүлэх, энэ хугацаанд ажилтны ажил үүргийг зохицуулах, чөлөө олгох, цалин хөлсийг олгох асуудлыг шийдэх, дэмжих	Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн - Ахлах түшмэлийн багц сургалтад 2, - Төрийн албан хаагчийн мэргэжлүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2, - Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэжлүүлэх дунд хугацааны сургалтад 3, - Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 2 албан хаагч тус тус хамрагдсан ба ажлын цагийн уян хатан нөхцөлөөр хангаж ажилласан.
6	Албан хаагчдын сургалт хөгжлийн чиглэлээр	Шинээр ажилд орж буй ажилтан, албан хаагчид агентлагийн хөдөлмөрийн дотоод журам, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулах	2023 оны байдлаар төрийн үйлчилгээний болон төрийн захиргааны 14 (шинээр 6, амаржсаны амралтаас 1, шилжин томилогдсон 7) албан хаагч томилогдсон. Шинээр хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй ажилтанд байгууллагын дотоод журам болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулан гарын үсэн зуруулсан. Байгууллагын дотоод журмыг дотоод сүлжээнд, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг байгууллагын цахим хуудсанд тус тус байршуулж, нийт албан хаагчид танилцах нээлттэй боломжийг бүрдүүлсэн.
7	Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагийг үр ашгтай өнгөрөөх чиглэлээр	Албан хаагчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулах	2023 оны төсвийн төлөвлөгөөнд албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах зардлыг тусгасан боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг хэмнэх зорилгоор хасаж баталсан. Монгол Японы эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний төслийг удирдлагад танилцуулсан. Гэрээ батлагдмагц бүх ажилтан албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулахаар ажиллаж байна.
9	Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагийг үр ашгтай өнгөрөөх чиглэлээр	Нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Хүүхдийн баяр, шинэ жилийн баярыг тохиолдуулан албан хаагчдын 0-16 насны 55 хүүхдэд баярын мэндчилгээ, бэлэг хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.
10	Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагийг үр ашгтай өнгөрөөх чиглэлээр	Хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулах	2023 оны төсвийн төлөвлөгөөнд уг зардлыг төлөвлөсөн боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг хэмнэх шалтгаанаар хасагдсан тул энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй болсон. Эрүүл мэндийн шалтгаантай 2 албан хаагч, ар гэрийн гачигдалтай 2 албан хаагчид цалинтай чөлөө олгосон. /А.Амаржаргал, С.Шинэ-Од, Г.Алтанхуяг, М.Бадамцэцэг/
11	Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагийг үр ашгтай өнгөрөөх чиглэлээр	Хүндээр өвчилсөн болон хүнд өвчний улмаас гадаад улс руу өндөр төлбөртэй эмчилгээ, сувилгаанд явах шаардлагатай албан хаагчдад хандив, туслалцаа үзүүлэх	

Тайлбар: Төрийн албаны тухай хууль, хөдөлмөрийн тухай хуульд албан хаагчдын нийгмийн баталгааг хангах асуудлыг хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлэхээр заагдсан хэдий ч байгууллагын 2023 оны төсөвт уг төрлийн зардал огт тусгаагаагүй тул дээрх арга хэмжээг байгууллагын дотоод нөөц бололцоо, УУХҮЯ-нд уламжлан нэмэлт зохицуулалтаар зохих түвшинд хэрэгжүүлсэн.

ХЯНАСАН: ТЗУХ-ИЙН ДАРГА

С.ШИНЭ-ОД

ТАЙЛАН ГАРГАСАН: ТЗУХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

П.ЛХАГВАДУЛАМ

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ АЛБАН ХААГЧДЫН 2023 ОНЫ СУРГАЛТЫН ТАЙЛАН

2023 онд Сургалтын төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг ханган ажилласан. Төлөвлөгөөнд тусгагдсан сургалтууд цахим болон танхимаар зохион байгуулагдсан. 2023 онд дотоод нөөц бололцоо, төсөл хөтөлбөрийн хүрээнд нийт сургалтуудад албан хаагчдыг хамруулсан. Үүнд:

Бүх нийтээр хамрагдах сургалт-11 70671
Мэргэжлийн болон мэргэшүүлэх, бусад сургалт-27

Д/д	Сургалтын ангилал	Сургалт зохион байгуулагч	Сургалтын сэдэв	Сургалт зохион байгуулах хугацаа	Хамрагдсан хүний тоо	Хэрэгжилт
1	Хувь хүний хөгжил, манлайлал	Мерит төсөл	Олборлох салбарын жендэрийн талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний эхэн үеийн хэрэгжилтийн тайланд хийсэн үнэлгээний дагуу цаашдын төлөвлөлтөд зөвлөмж дүгнэлт өгөх сургалт, семинар	2-р улиралд	1	2023.06.20-нд зохион байгуулагдсан сургалтад 1 албан хаагч хамрагдав.
2			Ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээ+ цахим сургалт	3-р улиралд	5	2023.09.30-нд зохион байгуулагдсан цахим сургалтад 5 албан хаагч хамрагдав.
3			Жендэрийн мэдрэмжтэй харилцаа, холбоо цахим сургалт	4-р улиралд	1	2023.11.01-нд зохион байгуулагдсан цахим сургалтад 1 албан хаагч хамрагдав.
4		BGR төсөл	ОУ-ын тайлангийн стандартын харьцуулалт болон хөрвүүлэлт, ашигт малтмалын баялаг ба ордын нөөцийн эдийн засгийн тооцоо болон баланс хийх	2-р улиралд	6	2023.04.13-21-нд зохион байгуулагдсан сургалтад 6 албан хаагч хамрагдав.
5		Амеп төсөл	"БОНЗ-ын арга зүй"	2-р улиралд	2	2023.05.02-нд зохион байгуулагдсан сургалтад 2 албан хаагч хамрагдав.
6		ССОР төсөл	Геологийн дээжийн өгөгдлийн сангийн системийн сургалт	3-р улиралд	1	2023.09.13-15-нд зохион байгуулагдсан сургалтад 1 албан хаагч хамрагдав.
7	Хувь хүний хөгжил, манлайлал	Япон Улсын геологийн алба, УГА	Геопаркийн үндэсний сүлжээтэй танилцах сургалт	1-р улиралд	1	2023.01.17-31-нд зохион байгуулагдсан сургалтад 1 албан хаагч хамрагдав.
8		Монголын геологийн холбоо	Монгол орны кайнозын үеийн тектоник ба геоморфологи	2-р улиралд	1	2023.04.23-нд зохион байгуулагдсан сургалтад 1 албан хаагч хамрагдав.
9		Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И-Монгол академи, АЕГазар	Албан бичиг солилцооны дундын системийн ашиглалт	2-р улиралд	1	2023.05.23, 24-нд зохион байгуулагдсан сургалтад 1 албан хаагч хамрагдав.
10		ШУТИС, УГА, "ГСШТ" ТӨҮГ	Геологийн судалгаа	2-р улиралд	2	2023.05.02-нд зохион байгуулагдсан сургалтад 2 албан хаагч хамрагдав.

11		АТГазар	Авлигын эсрэг давтан сургалт	3-р улиралд	1	2023.09.29-нд танхимын сургалтад 1 албан хаагч хамрагдав.	
12		Гэр бүл, хувь хүний хөгжлийн тухай Хөгжлийн Салхи Манлайллын академи	"Гэрэлгүй хүн" /Гэр бүлийн хүчирхийлэл/ сэдэвт сургалт	4-р улиралд	28	2023.10.27-нд нийт албан хаагчдад зориулсан танхимын сургалтад 28 албан хаагч хамрагдав.	
13			"Хөгжлийн бэрхшээл хүний эрхийг хангах, ойлголт өгөх талаар сургалт	4-р улиралд	23	2023.11.03-нд нийт албан хаагчдад зориулсан танхимын сургалтад 23 албан хаагч хамрагдав.	
14			Байгууллагын алсын хараа, хувь хүний манлайлал	4-р улиралд	24	2023.11.10-нд нийт албан хаагчдад зориулсан танхимын сургалтад 24 албан хаагч хамрагдав.	
15	Хувь хүний хөгжил, манлайлал	ТАЗ	Авлигаас урьдчилан сэргийлэх болон Албан тушаалтны ХАСХОМ шинэчлэн гаргахад анхаарах асуудал	1-р улиралд	20	2023.02.02-нд нийт албан хаагчдад зориулсан цахим сургалтад 20 албан хаагч хамрагдав.	
16				"Төрийн албан хаагч"	1-р улиралд	15	2023.03.02-нд нийт албан хаагчдад зориулсан цахим сургалтад 15 албан хаагч хамрагдав.
17				"Төрийн албаны шинэтгэл: сонгон шалгаруулалтын зохицуулалт"	2-р улиралд	12	2023.04.06-нд нийт албан хаагчдад зориулсан цахим сургалтад 12 албан хаагч хамрагдав.
18				Төрийн албан хаагч ба дипломат ёслол	4-р улиралд	14	2023.10.19-нд нийт албан хаагчдад зориулсан цахим сургалтад 14 албан хаагч хамрагдав.
19				Аз жаргалтай ажлын байр, Стресс менежмент	4-р улиралд	20	2023.11.02-нд нийт албан хаагчдад зориулсан цахим сургалтад 20 албан хаагч хамрагдав.
20				Амжилтад хүрэх хүсэл	4-р улиралд	21	2023.11.09-нд нийт албан хаагчдад зориулсан цахим сургалтад 21 албан хаагч хамрагдав.
21				Төрийн сүлдний бэлгэдэл /УИХ-ын дарга Г.Занданшатар урилгаар оролцсон/	4-р улиралд	11	2023.11.30-нд нийт албан хаагчдад зориулсан цахим сургалтад 11 албан хаагч хамрагдав.
22	Мэргэшүүлэх сургалт	УУХҮЯам, МГХНЗөвлөл	Мэргэшсэн инженер	2-р улиралд	1	2023.05.18-нд 1 албан хаагч Мэргэшсэн инженер болсон.	
23				Зөвлөх геологич	2-р улиралд	1	2023.06 сард 1 албан хаагч Зөвлөх геологич болсон.
24				Мэргэшсэн геологич	2-р улиралд	1	2023.06.20-нд 1 албан хаагч Мэргэшсэн геологич болсон
25		Архивын ерөнхий газрын	Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтны мэргэжлийн сургалт	2-р улиралд	1	2023.04.03-05.05-ныг дуустал хугацаанд мэргэжлийн сургалтад 1 албан хаагч хамрагдав.	
26				Цахим албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандарт архивын талаарх сургалт	2-р улиралд	25	2023.06.15-нд нийт албан хаагчдад зориулсан сургалтад 25 албан хаагч хамрагдав
27			Удирдлагын академи	Их өгөгдлийг бодлогын шийдвэрт ашиглах нь	1-р улиралд	1	2023.03.21, 23-нд танхимын сургалтад 1 албан хаагч хамрагдав
28				Чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага	3-р улиралд	1	2023.09.28-10.06-нд 1 албан хаагч танхимын сургалтад хамрагдав
29				Төрийн байгууллагын шийдвэр, хууль хэрэглээ	4-р улиралд	1	2023.10.05-06-нд 1 албан хаагч танхимын сургалтад хамрагдав
30				Төрийн албан хаагчдад зориулсан "Хүний эрх" 1-р түвшин	4-р улиралд	1	2023.10.26-нд цахим сургалтад 1 албан хаагч хамрагдав.

31			Төрийн албан хаагчдад зориулсан "Ёс зүй" 1-р түвшин	4-р улиралд	1	2023.10.26-нд цахим сургалтад 1 албан хаагч хамрагдав.
32			Төрийн албан хаагчдад зориулсан "Авлигаас ангид төрийн алба" 1-р түвшин	4-р улиралд	1	2023.10.30-нд цахим сургалтад 1 албан хаагч хамрагдав.
33		Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт	Мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхийн сургалт	3-4-р улиралд	1	2023.09.18-10.18-ныг дуустал хугацаанд 1 албан хаагч хамрагдав.
34		Жендэрийн үндэсний хороо	Жендэрийн үндэсний сургагч багш бэлтгэх	1-р улиралд	1	2023.03.23, 24-нд зохион байгуулагдсан сургалтад 1 албан хаагч хамрагдав.
35	Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтууд	Удирдлагын академийн Төрийн албаны сургууль	Ахлах түшмэлийн багц	жилдээ	2	2023.02.27-05.27-ныг дуустал хугацаанд 1 албан хаагч хамрагдсан. 2023.10.15-наас 1 албан хаагч хамрагдаж эхэлсэн.
36			Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт	жилдээ	2	2023.02.06-05.06-ныг дуустал хугацаанд 1 албан хаагч хамрагдаж төгссөн, 2023.09 сараас 1 албан хаагч хамрагдаж эхэлсэн.
37			Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт	жилдээ	3	2023.02.06-05.06-ныг дуустал хугацаанд 2 албан хаагч, 2023.02.27-05.27-ныг дуустал хугацаанд 1 албан хаагч хамрагдсан ч төгсөж чадаагүй амаржсаны амралтаа авсан.
38			Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалт	жилдээ	2	2023.10.09-20-ныг дуустал хугацаанд 2 албан хаагч хамрагдав.

ХЯНАСАН: ТЗУХ-ИЙН ДАРГА

С.ШИНЭ-ОД

ТАЙЛАН ГАРГАСАН: ТЗУХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

П.ЛХАГВАДУЛАМ

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:

Хүний нөөц сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Мөнхтуяа

Холбоо барих утас: 70181208

Цахим шуудан: b.munkhtuya@ngs.gov.mn